# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 08 дугаар сарын 21
№31 (1279)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | |
|---|---|---|
| 406. | Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ | 2305 |
| 407. | Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2351 |
| 408. | Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2352 |
| 409. | Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2353 |
| 410. | Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2354 |
| 411. | Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2355 |
| 412. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2356 |
| 413. | Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2357 |
| 414. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2358 |
| 415. | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2359 |
| 416. | Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2360 |
| 417. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2361 |
| 418. | Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2363 |
| 419. | Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2364 |
| 420. | Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай | 2367 |
| 421. | Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2368 |

| | | |
|---|---|---|
| 422. | Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2370 |
| 423. | Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2371 |
| 424. | Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2372 |
| 425. | Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2373 |
| 426. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2374 |
| 427. | Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2375 |
| 428. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай | 2376 |
| 429. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2377 |
| 430. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай /Шинэчилсэн найруулга/ | 2378 |
| 431. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2393 |
| 432. | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2394 |
| 433. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2395 |
| 434. | Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2397 |
| 435. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2398 |

| | | |
|---|---|---|
| 436. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2401 |
| 437. | Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2402 |
| 438. | Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2403 |
| 439. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2404 |
| 440. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2405 |
| 441. | Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2406 |
| 442. | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2407 |
| 443. | Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2408 |
| 444. | Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2409 |
| 445. | Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2411 |
| 446. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай /Шинэчилсэн найруулга/ | 2413 |
| 447. | Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2421 |
| 448. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2422 |
| 449. | Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2423 |
| 450. | Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 2424 |

| | | | |
|---|---|---|---|
| 451. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ | | 2425 |
| 452. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 2438 |
| 453. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2439 |
| 454. | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 2440 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 455. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 53 | 2442 |
| 456. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 54 | 2443 |

ᠭᠠᠷᠴᠠᠭ

[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]

| | | |
|---|---|---|
| ᠔᠑᠙. | [illegible] | ᠒᠓᠖᠔ |
| ᠔᠒᠐. | [illegible] | ᠒᠓᠖᠗ |
| ᠔᠒᠑. | [illegible] | ᠒᠓᠖᠘ |
| ᠔᠒᠒. | [illegible] | ᠒᠓᠗᠐ |
| ᠔᠒᠓. | [illegible] | ᠒᠓᠗᠑ |
| ᠔᠒᠔. | [illegible] | ᠒᠓᠗᠒ |
| ᠔᠒᠕. | [illegible] | ᠒᠓᠗᠓ |
| ᠔᠒᠖. | [illegible] | ᠒᠓᠗᠔ |
| ᠔᠒᠗. | [illegible] | ᠒᠓᠗᠕ |
| ᠔᠒᠘. | [illegible] | ᠒᠓᠗᠖ |
| ᠔᠒᠙. | [illegible] | ᠒᠓᠗᠗ |
| ᠔᠓᠐. | [illegible] | ᠒᠓᠗᠘ |
| ᠔᠓᠑. | [illegible] | ᠒᠓᠙᠓ |
| ᠔᠓᠒. | [illegible] | ᠒᠓᠙᠔ |

| | | |
|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| | Moehgo& Folo_ oa YekEt Hore& oa Doeedege& | |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн даатгалд даатгуулах, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүргийг тодорхойлох харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль[2], Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль[3], Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль[4], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, нийгмийн даатгалын байгууллага болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдэд хамаарна.

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

[2] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

[3] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

[4] Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

3.2.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ажил олгогч” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн[5] 4.1.1-д заасныг;

4.1.2.“даатгуулагч” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах зорилгоор нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж даатгуулсан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

4.1.3.“итгэлцүүр” гэж өмнөх үеийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох зорилгоор тогтоосон илэрхийллийг;

4.1.4.“мөнгөжүүлсэн орлого” гэж тэтгэврийн даатгалын нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсгийг;

4.1.5.“нийгмийн даатгал” гэж даатгуулагч, ажил олгогч, төрөөс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр олгох, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээг;

4.1.6.“нийгмийн даатгалын байгууллага” гэж нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

[5] Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

4.1.7.“нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан” гэж ажил олгогч, даатгуулагчийн мэдээлэл, цалин хөлсний сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэл, олгосон тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээллийг цуглуулсан, боловсруулсан, хадгалсан цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг;

4.1.8.“нийгмийн даатгалын сан” гэж тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зорилгоор ажил олгогчийн цалин хөлсний сан, даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

4.1.9.“нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл” гэж нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн эцсийн үлдэгдлээс 2 сарын хугацааны тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал болон ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд зарцуулах хөрөнгийн хэмжээг хасаж тооцсон үлдэгдэл мөнгөн хөрөнгийг;

4.1.10.“нийгмийн даатгалын шимтгэл” гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч, ажил олгогч, төрөөс энэ хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан төлсөн мөнгөн хөрөнгийг;

4.1.11.“нийгмийн даатгалын шимтгэл төлөгч” гэж энэ хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд шимтгэл төлөх үүрэг хүлээсэн даатгуулагч, ажил олгогч, төр, хуулийн этгээдийг;

4.1.12.“тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн[6] 4.1.3-т заасныг;

4.1.13.“тэтгэвэр” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагч, хүнд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.14.“тэтгэвэр авагч” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр тогтоолгон авч байгаа хүнийг;

---

[6] Цахим гарын үсгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

4.1.15.“тэтгэврийн даатгалын нэрийн данс” гэж даатгуулагчийн гарааны үлдэгдэл, төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэл, тооцсон хүү, мөнгөжүүлсэн орлого, олгосон тэтгэвэр зэрэг орлого, зарлагыг нэгтгэн тооцсон даатгуулагч бүрийн бүртгэлийг;

4.1.16.“тэтгэмж” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу эрх үүссэн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болох тохиолдолд өөрт нь, нас барахад түүний гэр бүлийн гишүүнд нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.17.“цалин хөлс, түүнтэй адилтгах орлого” гэж Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль[7], Иргэний хуульд[8] заасан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс, олговор, хөлс, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажил олгогчоос сар, улирал, жил тутам, эсхүл тухайн тохиолдол бүрд олгож байгаа шагнал, урамшуулал, хоол, унаа, орон сууцны ашиглалтын төлбөр, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлт, сайн дураар даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогыг;

4.1.18.“цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.10-т заасныг;

4.1.19.“эрүүл мэндийн магадлал” гэж даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвараа алдсан шалтгаан, хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, хяналт тавих мэргэжлийн үйл ажиллагааг.

**5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын зарчим**

5.1.Нийгмийн даатгал дараах зарчмыг баримтална:

5.1.1.даатгуулагч, ажил олгогч, төрийн оролцоог хангасан байх;

5.1.2.санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх;

5.1.3.нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх;

5.1.4.тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих бодлогод тулгуурласан байх.

[7] Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[8] Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

**6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын төрөл**

6.1.Нийгмийн даатгал дараах төрөлтэй байна:

6.1.1.тэтгэврийн даатгал;
6.1.2.тэтгэмжийн даатгал;
6.1.3.ажилгүйдлийн даатгал;
6.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;
6.1.5.эрүүл мэндийн даатгал.

**7 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ**

7.1.Нийгмийн даатгал нь албан журмаар болон сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

7.2.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан журмаар даатгуулна:

7.2.1.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан;

7.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;

7.2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;

7.2.4.нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа энэ хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3-т заасан ажилтан;

7.2.5.хууль бусаар ажлаас халагдсан хүн;
7.2.6.хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хүн.

7.3.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах хүн албан журмаар даатгуулна:

7.3.1.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

7.3.2.бүх шатны сонгуулийн хэсэг, хороонд ажиллахаар томилогдсон Монгол Улсын иргэн;

7.3.3.хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн;

7.3.4.ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль[9], Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд[10] заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч.

7.4.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах хүн албан журмаар даатгуулна:

7.4.1.улсын хил дээр алба хааж, ажиллаж байгаа офицер, ахлагчийн болон гаалийн улсын байцаагчийн хөдөлмөр эрхлээгүй нөхөр, эхнэр;

7.4.2.зэвсэгт хүчин, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч өөр аймаг, хот, суурин газарт шилжин ажилласны улмаас түүний хөдөлмөр эрхлээгүй байгаа нөхөр, эхнэр;

7.4.3.шашны байгууллагын лам, санваартан;

7.4.4.ажил олгогчийн захиалгаар суралцаж байгаа ажилтан, төрийн албан хаагч;

7.4.5.гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хөдөлмөрийн гэрээтэй ажилтан эх, эсхүл эцэг, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг;

7.4.6.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны хөдөлмөр эрхлээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй нөхөр, эхнэр;

7.4.7.гамшгаас хамгаалах болон бусад дайчилгаагаар ажилласан хүн;

[9] Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.
[10] Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

7.4.8.цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан;

7.4.9.хугацаат цэргийн алба хаагч;

7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.

7.5.Энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд дараах хүн албан журмаар даатгуулна:

7.5.1.үндсэн ажлын цагаасаа бусад цагт Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хэд хэдэн ажил зэрэг гүйцэтгэж байгаа ажилтан;

Тайлбар: “үндсэн ажил” гэж хэд хэдэн ажил олгогчтой гэрээ байгуулан ажиллах тохиолдолд долоо хоногийн ажлын цагийн ихэнхийг зарцуулж байгаа, эсхүл ажлын цагийн зарцуулалтыг тодорхойлох боломжгүй бол цаг хугацааны хувьд эхэлж гэрээ байгуулсан ажил, албан тушаалыг.

7.5.2.хөдөлмөр эрхлээгүй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч.

7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

7.7.Энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д зааснаас бусад хүн энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд сайн дураар даатгуулж болно.

7.8.Энэ хуулийн 7.3.4-т зааснаас бусад тэтгэвэр авагч сайн дураар даатгуулахгүй.

7.9.Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан хугацаанд сайн дураар давхар даатгуулахгүй.

7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-т заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.

**8 дугаар зүйл.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ**

8.1.Энэ хуулийн 7.7-д заасан хүн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулна.

8.2.Даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, шимтгэл төлөх хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах, цуцлах, дуусгавар болгох зэрэг харилцааг зохицуулсан журам болон сайн дураар даатгуулах гэрээний загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3.Сайн дураар даатгуулах гэрээг цахимаар байгуулж болно.

**9 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах сонголт хийх**

9.1.Даатгуулагч нийгмийн даатгалын сангаас хоёр ба түүнээс дээш төрлийн тэтгэвэр тогтоолгон авах эрх зэрэг үүсвэл өөрт таатай нөхцөлтэй нэг төрлийн тэтгэврийг нэг удаа сонгоно.

9.2.Даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу хоёр тэтгэвэр авах эрх үүсэхээр бол шимтгэл төлсөн болон цэргийн алба хаасан хугацааг нэгтгэн тооцож, нэг тэтгэвэр тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

**10 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сан**

10.1.Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь дараах мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна:

10.1.1.тэтгэврийн даатгалын сан;
10.1.2.тэтгэмжийн даатгалын сан;
10.1.3.ажилгүйдлийн даатгалын сан;
10.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан;

10.1.5.эрүүл мэндийн даатгалын сан.

10.2.Нийгмийн даатгалын сан тус бүр банканд данстай байна.

**11 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн орлого**

11.1.Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

11.1.1.даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;

11.1.2.ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;

11.1.3.төрөөс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;

11.1.4.сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого;

11.1.5.нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль;

11.1.6.улсын төсвөөс олгох хөрөнгө;

11.1.7.хуульд заасан бусад эх үүсвэр.

**12 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн зарлага**

12.1.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна:

12.1.1.тэтгэвэр, тэтгэмж олгох;

12.1.2.даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

12.1.3.банкны тэтгэвэр олгосон үйлчилгээний хөлс;

12.1.4.энэ хуулийн 13.3-т заасан зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал;

12.1.5.нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн төлбөр;

12.1.6.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх.

12.2.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

12.3.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ.

12.4.Энэ хуулийн 12.3-т заасан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, хугацаа, хяналт тавих журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

## 13 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага

13.1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно:

13.1.1.Засгийн газрын үнэт цаас;
13.1.2.Монголбанкны үнэт цаас;
13.1.3.Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж;

13.1.4.Банкны тухай хуулийн[11] 3.1.20-д заасан арилжааны банк /цаашид “арилжааны банк” гэх/-нд байршуулах мөнгөн хадгаламж.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байна.

13.4.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2-т заасан үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

13.5.Энэ хуулийн 13.1.3-т заасан мөнгөн хадгаламжид тооцох хүүгийн хэмжээ нь Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээтэй тэнцүү байна.

13.6.Энэ хуулийн 13.1.4-т заасан мөнгөн хадгаламжийн хэмжээ нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас ихгүй байна.

13.7.Олон нийтийн хяналтын зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, даатгуулагчийн төлөөлөл бүхий 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг зөвлөлийн дүрмийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

13.8.Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн

[11] Банкны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс тооцсон жигнэсэн дундаж хүүгээс доошгүй байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

13.9.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална.

**14 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсөв боловсруулах, батлах**

14.1.Нийгмийн даатгалын сангийн төсвийг Төсвийн тухай хуулийн[12] 8.4-т заасан цаглаврын дагуу боловсруулна.

14.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.3.Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

14.4.Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу улсын төсвөөс олгох болон 1995 оноос өмнө тогтоосон тэтгэвэрт зарцуулах хөрөнгө, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг жил бүрийн улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөвт тусган батална.

14.5.Энэ хуулийн 11.1.6-д заасан хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сарын хуваарийн дагуу тухайн сарын эхний 10 хоногт багтаан зохих санд шилжүүлнэ.

**15 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл**

15.1.Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг олон улсын болон үндэсний стандартын дагуу аккруэл сууриар хөтөлнө.

15.2.Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, түүнийг хөтлөх аргачлалыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

[12] Төсвийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

15.3.Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах, тайлагнах журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

15.4.Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын сан тус бүрд төлсөн шимтгэл, тэтгэвэр, тэтгэмж, даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг ажил олгогч, даатгуулагч тус бүрээр бүртгэнэ.

**16 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах**

16.1.Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын сангийн улирал, хагас жил, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараах цаглаврын дагуу боловсруулж, тайлагнана:

16.1.1.сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын сангийн улирал, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу;

16.1.2.аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын сангийн хагас жил, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-т, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөн хуулийн 8.9.5-д тус тус заасны дагуу.

16.2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нийгмийн даатгалын сангийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор, нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 05 дугаар сарын 25-ны дотор хянан хэлэлцэнэ.

16.3.Нийгмийн даатгалын байгууллага Төсвийн тухай хуулийн 8.9-д заасан хугацаанд нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлнэ.

16.4.Нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, түүнд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, улсын төсвийн гүйцэтгэлийг баталснаас хойш 20 хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

16.5.Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**17 дугаар зүйл.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан**

17.1.Нийгмийн даатгалын байгууллага шимтгэл төлөгч, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчийн, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сантай байна.

17.2.Нийгмийн даатгалын байгууллага энэ хуулийн 17.1-д заасан мэдээллийг судалгаа, шинжилгээ, үнэлгээ, хэтийн тооцоолол, хяналт шалгалт хийх, мэдээ, тайлан гаргах, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор ашиглана.

17.3.Нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, хүнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх зорилгоор төрийн бусад байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглана.

17.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

**18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ**

18.1.Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

| Нийгмийн даатгалын төрөл | Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ | Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ |
|---|---|---|
| 1.Тэтгэврийн даатгал | 8.5 | 8.5 |
| 2.Тэтгэмжийн даатгал | 1.0 | 0.8 |

| | | |
|---|---|---|
| 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал | 0.5, 1.5, 2.5 | - |
| 4.Ажилгүйдлийн даатгал | 0.5 | 0.2 |
| Шимтгэлийн дүн | 10.5, 11.5, 12.5 | 9.5 |

18.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

18.3.Энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр гэрээгээр тохиролцсон хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

| Нийгмийн даатгалын төрөл | Даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ |
|---|---|
| 1.Тэтгэврийн даатгал | 11.5 |
| 2.Тэтгэмжийн даатгал | 1.0 |
| 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал | 1.0 |
| Шимтгэлийн дүн | 13.5 |

18.4.Энэ хуулийн 7.3.3-т заасан Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

18.5.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар[13] зохицуулна.

**19 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн**

19.1.Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна:

19.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор;

[13] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

19.1.2.Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс;

19.1.3.ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал;

19.1.4.үндсэн ажлаас бусад хуулийн этгээд, хүнээс олгосон энэ хуулийн 19.1.1-д заасан цалин хөлс, олговор;

19.1.5.Төрийн албаны тухай хуулийн 57.2-т заасан цалин хөлс;

19.1.6.бүх шатны сонгуулийн хэсэг, хороонд ажилласан ажилтанд олгосон урамшуулал;

19.1.7.сайн дураар даатгуулагчийн өөрөө мэдүүлж, гэрээгээр тохирсон орлого.

19.2.Даатгуулагч, ажил олгогчийн шимтгэл ногдох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

19.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтны шимтгэл ногдох цагийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

19.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.

**20 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэл**

20.1.Ажил олгогч улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлнэ.

20.2.Нийгмийн даатгалын байгууллага ажил олгогч, даатгуулагчийг бүртгэж, шимтгэл төлөгчийн дугаар олгоно.

20.3.Нийгмийн даатгалын байгууллага ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг тусгасан хувийн хэрэг нээж, тухай бүрд мэдээллийн баяжилт хийнэ.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан хувийн хэрэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, сайн дураар даатгуулах гэрээ, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтын удирдамж, тайлан, мэдэгдэл, акт, албан шаардлага, шийтгэлийн хуудас зэргийг тухай бүр хавсаргана.

20.5.Бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам, холбогдох маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**21 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт**

21.1.Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө.

21.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын ажил олгогч Монгол Улсын иргэнийг ажиллуулж байгаа бол түүний нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 21.1-д заасны дагуу нийгмийн даатгалын санд төлнө.

21.3.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, ажил олгогчийн төлөөлөгчийн газар, төлөөний газрын ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсад ажиллаж байгаа адилтгах албан тушаалын ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, тухайн ажилтныг томилон ажиллуулж байгаа ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө.

21.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2-т заасан хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг даатгуулагчийн ажиллаагүй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө.

21.5.Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3-т заасан ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийгмийн даатгалын санд сар бүр төлнө.

21.6.Энэ хуулийн 7.2.4-т заасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.7.Энэ хуулийн 7.2.5-д заасан хүний шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн шийдвэрт заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос, хэрэв шүүхийн шийдвэрт цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг заагаагүй бол түүний уг ажлаас халагдахын өмнө авч байсан сүүлийн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, буруутай этгээд нийгмийн даатгалын зохих санд нэг удаа төлнө.

21.8.Энэ хуулийн 7.2.6-д заасан хүний шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хилсээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, буруутай этгээд нийгмийн даатгалын зохих санд нэг удаа төлнө.

21.9.Энэ хуулийн 7.3.1, 7.3.2-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, урамшууллаас даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө.

21.10.Энэ хуулийн 7.3.3-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр даатгуулагч өөрөө хариуцан сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.11.Энэ хуулийн 7.4.1, 7.4.2-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч сар бүр төлнө.

21.12.Энэ хуулийн 7.4.3-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд ажил олгогч сар бүр төлнө.

21.13.Энэ хуулийн 7.4.4-т заасан даатгуулагчийн суралцах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.14.Энэ хуулийн 7.4.5-д заасан эх, эсхүл эцгийн хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.15.Энэ хуулийн 7.4.6-д заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.16.Энэ хуулийн 7.4.7-д заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, улс, орон нутгийн төсвөөс тухай бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.17.Энэ хуулийн 7.4.8-д заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, улсын төсвөөс нийгмийн даатгалын зохих санд улирал бүр төлнө.

21.18.Энэ хуулийн 7.4.9-д заасан хугацаат цэргийн алба хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, цэргийн анги, байгууллага хариуцан сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.19.Энэ хуулийн 7.5.2-т заасан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд төлнө.

21.20.Сайн дураар даатгуулагч энэ хуулийн 19.1.7-д заасан орлогоос сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын зохих санд төлнө.

21.21.Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг доор дурдсанаар тооцож сар бүр төлнө:

21.21.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 6.1-д заасан нөхцөлийг хүүхэд төрүүлэх бүрд хангаж жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас;

21.21.2.энэ хуулийн 21.21.1-д зааснаас бусад эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс.

21.22.Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

21.23.Малчин, туслах малчин энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.

21.24.Энэ хуулийн 21.21, 21.22, 21.23-т заасан даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон төлбөл зохих шимтгэлийн дүнгээс тэтгэмжийн даатгалын сан, улсын төсвөөс төлсөн шимтгэлийг хасаж, үлдэх хэсэг болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлнө.

21.25.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн ажил, хөдөлмөр эрхлэх хугацаанд энэ хуулийн 21.19-д заасан шимтгэлийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас давхардуулан төлөхгүй.

21.26.Цэргийн жинхэнэ алба хаагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол түүний цэргийн алба хаасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр дараах байдлаар тооцож, нийгмийн даатгалын зохих санд улсын төсвөөс тухай бүр төлнө:

21.26.1.цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг цэргийн алба хаагчийн авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн орлогоос;

21.26.2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс.

21.27.Дипломат албаны тухай хуулийн[14] 22.4-т заасны дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан өсгөн тооцсон хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд улсын төсвөөс тухай бүр төлнө.

21.28.Энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд[15] заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно.

21.29.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг гадаад харилцааны болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21.30.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

21.31.Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх харилцааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

**22 дугаар зүйл.Итгэлцүүрийг хэрэглэх, тогтоох**

22.1.Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход итгэлцүүр хэрэглэнэ.

22.2.Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө.

[14] Дипломат албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2000 оны 39 дугаарт нийтлэгдсэн.
[15] Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

22.3.Итгэлцүүрийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**23 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаа**

23.1.Дараах хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцно:

23.1.1.ажилтны 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацаа;

23.1.2.ажилтны төр, хувийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, шашны байгууллагад 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл ажиллаж, цалин хөлсний сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа;

23.1.3.Монгол Улсын иргэний 1995 оноос өмнө цэргийн жинхэнэ болон хугацаат цэргийн алба хаасан хугацаа;

23.1.4.тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацаа;

23.1.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн цэргийн жинхэнэ алба хаасан нэг жилийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нэг жил зургаан сараар тооцсон хугацаа;

23.1.6.1995 оноос өмнө ажилласан хугацааг холбогдох хуулийн дагуу нөхөн тооцож баталгаажуулсан хугацаа;

23.1.7.даатгуулагчийн Дипломат албаны тухай хуулийн дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан нэг жилийг нэг жил зургаан сараар тооцсон хугацаа.

23.2.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

**24 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх**

24.1.Дараах тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлнэ:

24.1.1.ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол;

24.1.2.ажил олгогч энэ хуулийн 21.1-д заасан хугацаанд төлөөгүй, эсхүл дутуу төлсөн бол;

24.1.3.сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон хугацаанд төлөөгүй бол;

24.1.4.хууль бусаар ажлаас халагдсан тухай шүүхийн шийдвэр гарсан бол;

24.1.5.хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн тухай шүүхийн шийдвэр гарсан бол.

24.2.Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд шимтгэл ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ.

24.3.Энэ хуулийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хориглоно.

24.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**25 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах**

25.1.Ажил олгогч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны дотор цахим, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж, харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, эсхүл нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр тайлагнана.

25.2.Дараах зөрчилд нийгмийн даатгалын улсын байцаагч акт тогтоосон бол нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг ажил олгогчоор нөхөн гаргуулна:

25.2.1.нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан, хэмжээг нь санаатайгаар бууруулсан, буруу тодорхойлсон;

25.2.2.нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн;

25.2.3.нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй.

**26 дугаар зүйл.Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох**

26.1.Нийгмийн даатгалын байгууллага илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг доор дурдсанаар буцаан олгоно:

26.1.1.илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн, эсхүл сайн дураар даатгуулагчийн хүсэлтэд үндэслэн дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох, эсхүл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор;

26.1.2.сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл урьдчилан төлсөн даатгуулагч хөдөлмөр эрхэлж, албан журмаар даатгуулсан бол давхардсан хугацааны сайн дураар төлсөн шимтгэлийг түүний хүсэлтэд үндэслэн 30 хоногийн дотор;

26.1.3.даатгуулагч хоёр ба түүнээс дээш байгууллагад хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийт дүн нь энэ хуулийн 19.4-т заасан дээд хэмжээнээс хэтэрсэн бол уг хэтэрсэн хэсэгт ногдох илүү төлсөн шимтгэлийг түүний хүсэлтэд үндэслэн дараа жилийн хоёрдугаар улиралд.

26.2.Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**27 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл**

27.1.Тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч тэтгэврийн даатгалын нэрийн данс /цаашид “нэрийн данс” гэх/-тай байна.

27.2.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагч бүрд нэрийн данс нээнэ.

27.3.Даатгуулагчийн нэрийн дансанд дараах орлогыг бүртгэнэ:

27.3.1.нэрийн дансны эхний үлдэгдэл;

27.3.2.даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэл;

27.3.3.ажил олгогчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэл;

27.3.4.нийгмийн даатгалын сангаас төлсөн шимтгэл;
27.3.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлсөн шимтгэл;
27.3.6.төрөөс төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэл;
27.3.7.нэрийн дансанд бүртгэсэн орлогод тооцсон хүү;
27.3.8.нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын хөрөнгө оруулалтын өгөөж.

27.4.Энэ хуулийн 27.3.2, 27.3.3, 27.3.4, 27.3.5, 27.3.6-д заасан шимтгэлийн орлогоос 4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэнэ.

27.5.Нэрийн дансны өмнөх оны эцсийн үлдэгдэл нь тухайн жилийн эхний үлдэгдэл байна.

27.6.Даатгуулагчийн энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, бүртгэсэн шимтгэлийн орлогод жил бүр хүү тооцож, бүртгэнэ.

27.7.Энэ хуулийн 27.6-д заасан тухайн жилийн хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтийг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно:

27.7.1.өмнөх оны инфляцын түвшин;
27.7.2.Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээ.

27.8.Даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг дараах томьёогоор бодно:

$$НД_{C2}=НД_{C1}-М+ БШО+Х_{о}$$

$НД_{C2}$-нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;
$НД_{C1}$-нэрийн дансны тухайн жилийн эхний үлдэгдэл;
БШО-тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлого;
$Х_{о}$-нэрийн дансны эхний үлдэгдлээс мөнгөжүүлсэн орлогыг хассан дүн, тухайн жилийн бүртгэсэн орлогод тооцсон хүүгийн орлого;
М-мөнгөжүүлсэн орлого.

27.9.Нэрийн дансны гарааны үлдэгдлийг 2000 оноос өмнө хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тооцох бөгөөд гарааны үлдэгдэл нь даатгуулагчийн нэрийн данс нээлгэсэн жилийн эхний үлдэгдэл байна.

27.10.Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

**28 дугаар зүйл.Нэрийн дансны орлогыг бүртгэх тусгай нөхцөл**

28.1.Албан журмаар даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг түүний сүүлийн 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас даатгуулагч, ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэж, хүү тооцно.

28.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 1995 оноос өмнө цэргийн алба хаасан хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр дараах орлогоос тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ:

28.2.1.цэргийн алба хаасан хугацаанд авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн орлогоос;

28.2.2.холбогдох хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцох хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс.

28.3.Энэ хуулийн 23.1.4-т заасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

28.4.Хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

**29 дүгээр зүйл.Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх**

29.1.Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна.

29.2.Энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нэрийн дансны эцсийн үлдэгдлийг дараах эх үүсвэрээс мөнгөжүүлнэ:

29.2.1.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн[16] 9.6-д заасан улсын төсөвт шилжүүлсэн орлогоос Засгийн газрын тогтоосон хэмжээгээр;

29.2.2.улсын төсвөөс олгох бусад орлого.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан тэтгэврийн нөөц сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

29.3.1.энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;

29.3.2.энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлого.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан орлогыг даатгуулагч бүрээр хуваарилж, тэтгэврийн нөөц сангийн дансанд байршуулна.

29.5.Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн доор дурдсанаар хөрөнгө оруулж болно:

29.5.1.энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд;
29.5.2.тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд.

29.6.Даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.

29.8.Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

[16] Ирээдүйн өв сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

**30 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн өр**

30.1.Доор дурдсан шимтгэл, алданги, торгуулийг шимтгэлийн өрд тооцно:

30.1.1.энэ хуулийн 21.1, 21.20-д заасан хугацаанд төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэл;

30.1.2.улсын байцаагчийн актаар төлүүлэхээр тогтоосон төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгууль;

30.1.3.шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр тогтоосон төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгууль.

**31 дүгээр зүйл.Хөөн хэлэлцэх хугацаа**

31.1.Дараах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаагүй байна:

31.1.1.энэ хуулийн 24.1-д заасан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх;

31.1.2.энэ хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.3-т заасан нийгмийн даатгалын шимтгэлд тооцсон алданги, торгуулийг төлүүлэх;

31.1.3.энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэх;

31.1.4.хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр тэтгэвэр, тэтгэмжийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг төлүүлэх.

31.2.Энэ хуулийн 31.1-д зааснаас бусад тохиолдолд Иргэний хуулийн 75.1-д заасан хугацааг баримтална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## АЖИЛ ОЛГОГЧ, ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**32 дугаар зүйл.Ажил олгогчийн эрх, үүрэг**

32.1.Ажил олгогч дараах эрх эдэлнэ:

32.1.1.ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх;

32.1.2.илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан авах буюу дараа төлөх шимтгэлд шилжүүлэн тооцуулах;

32.1.3.нийгмийн даатгалын асуудлаар лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл, зөвлөгөө авах болон сургалтад хамрагдах;

32.1.4.эрх бүхий байгууллагын шалгалтын дүн, акттай танилцах, тайлбар авах, өгөх;

32.1.5.нийгмийн даатгалын байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдлыг эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргах;

32.1.6.энэ хуулийн 32.1.5-д заасны дагуу гомдлыг хянан шалгаж гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд хандах;

32.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

32.2.Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ:

32.2.1.хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах;

32.2.2.орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;

32.2.3.нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;

32.2.4.энэ хуулийн 32.2.1-д заасан гэрээ байгуулсан, дуусгавар болгосон талаарх шийдвэр болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг тухай бүр нийгмийн даатгалын байгууллага, даатгуулагчид өгөх;

32.2.5.нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон акт, шийтгэлийн хуудас, тавьсан албан шаардлага, өгсөн мэдэгдлийг хугацаанд нь бүрэн биелүүлэх;

32.2.6.ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлөх;

32.2.7.нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллээр ажилтныг хангах;

32.2.8.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**33 дугаар зүйл.Даатгуулагчийн эрх, үүрэг**

33.1.Даатгуулагч дараах эрх эдэлнэ:

33.1.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангасан тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах;

33.1.2.илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан авах буюу дараа төлөх шимтгэлд шилжүүлэн тооцуулах;

33.1.3.нийгмийн даатгалын шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ажил олгогчийн болон өөрийн төлсөн шимтгэлийн хэмжээ, шимтгэл төлсөн хугацаа, нийгмийн даатгалын сангаас авсан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийн талаарх мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр авах;

33.1.4.нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт болон нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийн үндэслэлийг шалгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах;

33.1.5.ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ болон энэ хуулийн 21.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлсөн эсэхэд хяналт тавих;

33.1.6.ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй, дутуу, эсхүл хугацаа хожимдож төлөгдсөн, шимтгэл төлөлтийн тайланг ирүүлээгүй, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах баримт бичгийг даатгуулагчид болон нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд гаргаж өгөөгүйн улмаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг авч чадаагүй, эсхүл хугацаандаа бүрэн аваагүй бол учирсан хохирол, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд гарсан зардлыг ажил олгогчоор төлүүлэх;

33.1.7.тэтгэврийн нөөц сан дахь өөрийн мөнгөжүүлсэн орлогыг энэ хуулийн 29.5-д заасан хөрөнгө оруулалтад оруулах эсэхийг сонгох;

33.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх.

33.2.Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ:

33.2.1.нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлого тодорхойлох болон шимтгэл төлсөн хугацааг тооцох, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад шаардлагатай баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх;

33.2.2.ажил олгогчийн нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагааны талаар нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох байгууллагад мэдээлэх;

33.2.3.сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх;

33.2.4.нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийн тогтоолт, олголтод хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийг барагдуулах;

33.2.5.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

### 34 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим

34.1.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ.

34.2.Нийгмийн даатгалын байгууллага хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, ажил олгогч, даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэх, үйл ажиллагаа нь ил тод байх зарчим баримтална.

### 35 дугаар зүйл.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл

35.1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ нь Засгийн газар, даатгуулагч, ажил олгогч гурван талыг тэнцүү тоогоор төлөөлсөн орон тооны бус дараах гишүүнтэй байна:

35.1.1.Засгийн газрыг төлөөлж хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

35.1.2.даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс гурван хүн;

35.1.3.ажил олгогчийг төлөөлж ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагаас гурван хүн.

35.2.Энэ хуулийн 35.1.1-д заасан төлөөлөл нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд байна.

35.3.Ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

35.4.Улсын  Их Хурал энэ хуулийн 35.3-т заасан нэр дэвшигчийн сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө.

35.5.Үндэсний зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүнтэй байна.

35.6.Үндэсний зөвлөлийн дарга нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

35.7.Үндэсний зөвлөлийн дэд даргыг талууд зөвшилцөж, энэ хуулийн 35.1.2, 35.1.3-т заасан төлөөллөөс хоёр жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

35.8.Үндэсний зөвлөлийн гишүүн хуульд заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болохоос өмнө чөлөөлөгдөх тохиолдолд дараагийн гишүүнийг энэ хуулийн 35.3-т заасны дагуу сонгон шалгаруулж, чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар Улсын Их Хурлаас томилно.

35.9.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.9.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах болон нийгмийн даатгалын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

35.9.2.нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд санал өгөх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;

35.9.3.нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг хэлэлцэн, дүгнэлт, шийдвэр гаргах;

35.9.4.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, нийгмийн даатгалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байгууллага, судлаач, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг хуралдаанд оролцуулж, тайлбар, мэдээлэл авч, саналыг сонсох;

35.9.5.ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, нийгмийн даатгалын байгууллагад зөвлөмж, чиглэл өгөх;

35.9.6.нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын талаарх олон нийтийн итгэл, үнэмшлийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн технологи, программ хангамж, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулахад санал, дүгнэлт өгөх;

35.9.7.Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

35.9.8.Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой болон нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу тогтоол, дүрэм, журам, аргачлал батлах, зөвлөмж гаргах;

35.9.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

35.10.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

35.11.Үндэсний зөвлөл гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр улирал бүр хуралдана. Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

35.12.Үндэсний зөвлөл ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.

35.13.Үндэсний зөвлөл ажлын албатай байна. Ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

35.14.Ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарна.

35.15.Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

35.16.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.

35.17.Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус мэргэжлийн хороог Үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна.

35.18.Энэ хуулийн 35.17-д заасан мэргэжлийн хорооны гишүүнийг Үндэсний зөвлөл нээлттэй сонгон шалгаруулах журмаар томилж, чөлөөлнө.

35.19.Үндэсний зөвлөлийн ажлын албаны бүтэц, ажиллах журам, энэ хуулийн 35.17-д заасан мэргэжлийн хорооны ажиллах журам, мэргэжлийн хорооны гишүүнд олгох урамшууллын хэмжээг Үндэсний зөвлөл батална.

35.20.Энэ хуулийн 35.19-д заасан урамшууллыг мэргэжлийн хорооны гишүүний ажлын үр дүнг харгалзан Үндэсний зөвлөл олгоно.

35.21.Үндэсний зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны зардал болон энэ хуулийн 35.16, 35.19-д заасан урамшууллыг улсын төсвөөс олгоно.

**36 дугаар зүйл.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

36.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

36.1.1.нийгмийн даатгалын бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл боловсруулах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны тооцоолол хийх;

36.1.2.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

36.1.3.нийгмийн даатгалын байгууллагыг бодлого, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

36.1.4.нийгмийн даатгалын байгууллагын орон тооны нормативыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн батлах;

36.1.5.гадаад улстай нийгмийн даатгалын асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, гэрээ конвенцод нэгдэх асуудлыг судлах, шийдвэрлүүлэх;

36.1.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

**37 дугаар зүйл.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага, эрх, чиг үүрэг**

37.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Үндэсний зөвлөлийн даргын болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлага доор тус тус ажиллана.

37.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

37.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлтэй байна.

37.4.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

37.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

37.6.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтныг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын ажилтныг тухайн шатны нийгмийн даатгалын байгууллагын дарга тус тус томилж, чөлөөлнө.

37.7.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл /цаашид “Магадлалын төв зөвлөл” гэх/-ийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл /цаашид “аймаг, дүүргийн магадлалын зөвлөл” гэх/-ийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэд, Сэтгэцийн өвчний салбар зөвлөл, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийг Магадлалын төв зөвлөлийн дэргэд тус тус ажиллуулна. Хүн амын тоо, нягтрал, байршил зэргийг харгалзан сумын нийгмийн даатгалын тасгийн дэргэд сумын эрүүл мэндийн магадлалын зөвлөл ажиллуулж болно.

37.8.Даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл /цаашид “төв зөвлөл” гэх/-ийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл /цаашид “салбар зөвлөл” гэх/-ийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэд тус тус ажиллуулна.

37.9.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээх, сувилах, хөдөлмөр зохицуулалт хийх, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллуулна.

37.10.Гадаад улсад түр болон байнга оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, нийгмийн баталгааг хангах, шимтгэлийн орлого бүрдүүлэх, гадаад улстай байгуулсан Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий нийгмийн даатгалын байгууллагын салбар нэгжийг тухайн улсад ажиллуулж болно.

37.11.Энэ хуулийн 37.9, 37.10-т заасан эмнэлэг, салбар нэгжийн даргыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тус тус томилж, чөлөөлнө.

37.12.Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ажиллах дүрмийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

37.13.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.13.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, чиглэл гаргах;

37.13.2.нийгмийн даатгалын хяналт шалгалтыг цахим хэлбэрээр болон баримт бичигт үндэслэн хийх, шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт бичгийг ажил олгогч, даатгуулагч, банк, санхүү, төрийн болон бусад байгууллага, албан тушаалтан, хүнээс үнэ төлбөргүй гаргуулах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

37.13.3.нийгмийн даатгалын доод шатны байгууллага, байцаагчийн тогтоосон шимтгэл, алданги, хүү, торгуулийг төлөхөөс зайлсхийсэн, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

37.13.4.нийгмийн даатгалын доод шатны байгууллагын гаргасан шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох, өөрчлөх;

37.13.5.нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

37.13.6.нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор даатгуулагч, хүний хувийн мэдээллийг ашиглах;

37.13.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

37.14.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

37.14.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах;

37.14.2.нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах, аймаг, нийслэлийн төсвийн нарийвчилсан хуваарийг батлах;

37.14.3.нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд даатгуулагч, ажил олгогчид олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

37.14.4.энэ хуулийн 29.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

37.14.5.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

37.14.6.тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийн хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах асуудлаар тооцоо, судалгаа хийж, санал боловсруулан Үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

37.14.7.доод шатны байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагааны зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх;

37.14.8.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах;

37.14.9.ажил олгогч, даатгуулагч, хүний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах;

37.14.10.нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, нийгмийн даатгалын байцаагч, ажилтныг тасралтгүй сургах, мэргэшүүлэх;

37.14.11.нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт болон хөрөнгө оруулалтын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах;

37.14.12.Үндэсний зөвлөлийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах;

37.14.13.татварын албатай цахимаар мэдээлэл харилцан солилцох;

37.14.14.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

37.15.Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрмийг Засгийн газар батална.

37.16.Энэ хуулийн 37.14.13-т заасан мэдээлэл харилцан солилцох журмыг нийгмийн даатгалын болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.

**38 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хяналт шалгалт, нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх, үүрэг**

38.1.Нийгмийн даатгалын хяналт шалгалтыг нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид “нийгмийн даатгалын улсын байцаагч” гэх/ хэрэгжүүлнэ.

38.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтөд хийх хяналт шалгалтыг нийгмийн даатгалын байгууллага хэрэгжүүлнэ.

38.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч байна.

38.4.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгож, баталгаажуулж, түдгэлзүүлж, цуцална.

38.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үндсэн чиг үүргийн нэгжийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга нь нийгмийн даатгалын улсын ахлах байцаагч байна.

38.6.Нийгмийн даатгалын улсын байцаагч нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, ёс зүйн зөрчил гаргаагүй, мэргэшсэн, нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн зэрэг шалгуурыг хангасан байна.

38.7.Нийгмийн даатгалын улсын байцаагч үнэмлэх, тэмдэгтэй байна.

38.8.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.9.Энэ хуулийн 38.2-т заасан хяналт шалгалт хийх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

38.10.Нийгмийн даатгалын улсын байцаагч дараах эрх эдэлнэ:

38.10.1.хөдөлмөрийн харилцаатай холбоотой баримт бичиг, цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах, төлөхтэй холбогдсон тайлан тэнцэл, санхүүгийн болон бусад баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

38.10.2.тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх зорилгоор ажил олгогч, банк, санхүү, архив, шүүх, эрүүл мэндийн болон бусад байгууллага, албан тушаалтан, хүнээс тайлбар, лавлагааг үнэ төлбөргүй гаргуулан авах;

38.10.3.нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлого нуусныг гэрчлэх, нотлох баримтыг ажил олгогч, даатгуулагч, хуулийн этгээд, хүнээс түр хугацаагаар хураан авах, эсхүл хуулбарлан авах;

38.10.4.илүү олгосон тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт болон нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг тэтгэвэр авагч, даатгуулагч, ажил олгогч, хүний банкан дахь данснаас үл маргах журмаар гаргуулах;

38.10.5.өөрийн хамаарал бүхий нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид шалгалт хийхээр томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэж, уг шалгалтыг хийхээс татгалзах;

38.10.6.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болон холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнд энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, шаардлагатай бол хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

38.10.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

38.11.Нийгмийн даатгалын улсын байцаагч дараах үүрэг хүлээнэ:

38.11.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх;

38.11.2.тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, эрүүл

мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах;

38.11.3.даатгуулагч, тэтгэвэр авагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

38.11.4.албан үүргээ гүйцэтгэх явцад ажил олгогч, даатгуулагч, хүн хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг илрүүлсэн бол холбогдох байгууллагад мэдэгдэх;

38.11.5.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**39 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын улсын байцаагчид хориглох зүйл**

39.1.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

39.1.1.удирдамж, томилолтгүйгээр хяналт шалгалт хийх;

39.1.2.нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт, албан шаардлага болон бусад баримт бичгийн хэвлэмэл хуудас, маягтыг үрэгдүүлэх, хууль бусаар хэвлэн ашиглах, хүчингүй буюу хуурамч хуудас хэрэглэх;

39.1.3.нийгмийн даатгалын улсын байцаагчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажаагүй акт, бусад баримт бичгийг ажил олгогч, даатгуулагч, хүнд урьдчилан танилцуулах, зөвшөөрүүлэхээр албадах;

39.1.4.ажил олгогч, даатгуулагч, хүн болон нийгмийн даатгалын улсын байцаагчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан акт, бусад баримт бичгийг засварлах, өөрчлөх;

39.1.5.ажил олгогч, даатгуулагч, хүнд нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт авахтай холбоотой хууль бус зөвлөгөө өгөх, нөхцөл боломж олгох;

39.1.6.нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, тэтгэвэр авагч, хүнээс гаргасан албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй өргөдөл, гомдол, мэдэгдлийг шалгаж шийдвэрлэх;

39.1.7.нийгмийн даатгалын мэдээллийн цахим сангийн мэдээллийг хууль бусаар өөрчлөх, халдах, засварлах, устгах, сэргээх, хуурамч мэдээлэл оруулах;

39.1.8.лавлагаа, эрүүл мэнд магадлалын шийдвэр, нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг хуурамчаар, эсхүл үндэслэлгүйгээр үйлдэх;

39.1.9.улсын байцаагчийн тэмдэг, дардсыг хууль бусаар ашиглах, бусдад хэрэглүүлэх;

39.1.10.албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн, байгууллагын болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулах, түүнийг хувийн ашиг сонирхлын төлөө ашиглах, хяналт шалгалтын дүн, албан ёсны шийдвэр гараагүй байхад аливаа асуудлын талаар байр сууриа илэрхийлэх, мэдээ, мэдээллийг задруулах;

39.1.11.хувийн зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчтэй холбогдож, түүнд аливаа хэлбэрээр зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын тайланг гаргах, аудит хийх, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийхэд туслах, шаардах;

39.1.12.хууль тогтоомжид заасан бусад хориглох зүйл.

**40 дугаар зүйл.Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэрэг**

40.1.Нийгмийн даатгалын улсын байцаагч нь нийгмийн даатгалын итгэмжит зөвлөх, нийгмийн даатгалын зөвлөх, нийгмийн даатгалын тэргүүлэх гэсэн мэргэшлийн зэрэгтэй байна.

40.2.Итгэмжит зөвлөх, зөвлөх, тэргүүлэх мэргэшлийн зэргийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

40.3.Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**41 дүгээр зүйл.Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ**

41.1.Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор дараах үйлчилгээг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд үзүүлнэ:

41.1.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах;

41.1.2.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх аргачлал, заавар, мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

41.1.3.нийгмийн даатгалд хамруулах, өндөр насны тэтгэвэрт бэлтгэх;

41.1.4.хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сургалт, сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх, түгээх ажлыг зохион байгуулах;

41.1.5.нийгмийн даатгалын үйлчилгээг цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр үзүүлэх.

**42 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл**

42.1.Энэ хуулийн 37.8-д заасан төв зөвлөл болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны бус байна.

42.2.Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны байх бөгөөд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд хамаарна.

42.3.Төв зөвлөл болон салбар зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төв зөвлөлийн бүрэлдэхүүнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, ажил олгогч, даатгуулагчийн төлөөлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллага, нутгийн захиргааны байгууллага, ажил олгогч, даатгуулагчийн төлөөлөл байна.

42.4.Төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

42.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга нь салбар зөвлөлийн дарга байна.

42.6.Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн салбар зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

42.7.Төв зөвлөл болон салбар зөвлөлийн хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулж, хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

42.8.Төв зөвлөл болон салбар зөвлөл нь тогтоол, тэмдэглэл, зөвлөмж гаргах бөгөөд түүнийг нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талууд хэрэгжүүлэх үүрэгтэй.

42.9.Даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, маргааныг шийдвэрлэсэн салбар зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл төв зөвлөлд, төв зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд хандана.

42.10.Төв зөвлөл болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан цагийн хөлс олгоно.

42.11.Энэ хуулийн 42.10-т заасан цагийн хөлсний хэмжээ, олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.12.Төв зөвлөл болон салбар зөвлөлийн эрх, үүрэг, хурлын дэг, маргаан шийдвэрлэх үйл явц, ажлын тайлан, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

**43 дугаар зүйл.Эрүүл мэндийн магадлалын зөвлөл**

43.1.Энэ хуулийн 37.7-д заасан Магадлалын төв зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч, шинжээч эмч болон даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. Магадлалын төв зөвлөлийн шинжээч эмч, даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл нь орон тооны бус байна.

43.2.Магадлалын төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл болон салбар зөвлөлийн гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

43.3.Магадлалын төв болон салбар зөвлөл, аймаг, дүүрэг, сумын магадлалын зөвлөлийн дарга, гишүүн, шинжээч эмчид хуралдсан цагаар нь тооцож сар бүр цагийн хөлс олгоно.

43.4.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм, энэ хуулийн 43.3-т заасан цагийн хөлсний хэмжээг Засгийн газар батална.

43.5.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт, зааврыг эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 44 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид дараах хариуцлага хүлээлгэнэ:

44.1.1.нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан, эсхүл хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол нуусан, эсхүл бууруулсан цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, мөн орлоготой тэнцэх хэмжээний алданги тооцно. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна;

44.1.2.төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар, эсхүл эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй, дутуу төлсөн бол хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги тооцно. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна;

44.1.3.тооцооны алдаа гаргаснаас нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн бол дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс тооцооны алдаа гарснаас хойш хоног тутамд 0.1 хувийн алданги тооцно. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 30 хувиас хэтрэхгүй байна;

44.1.4.тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгож, даатгуулагчийг хохироосон бол дутуу тооцсон хөдөлмөрийн хөлсөнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс дутуу тооцсоноос хойш хоног тутамд 0.1 хувийн алданги тооцно. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 30 хувиас хэтрэхгүй байна.

44.2.Тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг илүү тогтоолгон авсан бол эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухайн тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг илүү авсан этгээдээр холбогдох санд нөхөн төлүүлнэ.

44.3.Банк тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт,

чөлөөлөлтийг хугацаанд нь олгоогүй бол олговол зохих дүнгээс саатуулсан хоног тутамд тухайн үйлчлүүлдэг банкны иргэдийн хугацаатай хадгаламжийн хүүгээр тооцсон алдангийг ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, төлбөр авагчид төлнө.

44.4.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, эсхүл хууль бусаар ашиглаж орлого олсон бол хууль бусаар олсон орлого, учруулсан хохирлыг нийгмийн даатгалын санд буруутай этгээдээр төлүүлнэ.

44.5.Энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагч энэ хууль болон нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол энэ хуулийн 44.1.2, 44.1.3-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.6.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь, хугацааг үндэслэлгүйгээр тогтоосон, хугацааг сунгасан, хууль бусаар бусдад нөлөөлсөн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, учруулсан хохирлыг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлнэ.

44.7.Нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчигчид алданги тооцох, торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөрчлийн тухай хуульд[17] заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийн төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлнэ.

Тайлбар: Энэ хуулийн 44.1.3-т заасан “тооцооны алдаа” гэдэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн баталгаажсан тайланд залруулга хийх, даатгуулагчийн төрлийг өөрчлөн засах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг буруу тооцох зэрэг хамаарна.

44.8.Энэ хуулийг зөрчсөн эрх бүхий албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.9.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд энэ хууль, эсхүл Эрүүгийн хууль[18] болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[17] Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.
[18] Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

**45 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**

45.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

**46 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт**

46.1.Энэ хуулийн 9.2 дахь хэсэг энэ хууль хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа хүнд хамаарна.

46.2.Энэ хуулийн 29.2.1-д заасан хөрөнгийг Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9.6-д заасны дагуу 2030 оноос эхлэн улсын төсвөөс олгоно.

46.3.Энэ хуулийн 29.6 дахь хэсгийг 2030 оноос эхлэн хэрэгжүүлнэ.

**47 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

47.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1994 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠬᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠑᠙᠙᠔ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠓᠑ ᠦ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠬᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠬᠠᠯ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠢᠷᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠨ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠽᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1994 оны 06 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ахмад настны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай хууль[2]” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль[2]” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 282 дугаар зүйлийн 282.6.2 дахь заалтын “тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж, мөн зүйлийн 282.7 дахь хэсгийн “өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож” гэснийг “нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Дипломат албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дундаж хэмжээгээр бодож төр хариуцна” гэснийг “нөхөр, эхнэрийн ажиллаж байгаа ажил олгогч хариуцаж Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу төлнө” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 203 дугаар зүйлийн 203.2.4 дэх заалтын “эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисст” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөлд” гэж, 204 дүгээр зүйлийн 204.1.3 дахь заалтын “эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.Сүм хийд, лам санваартны нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу төлнө.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай[5]” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль[5]” гэж, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4, 7.5, 7.6 дахь” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “19.1.1, 19.1.2,” гэснийг “6.1.1, 6.1.11-д заасан эрүүл мэндийн даатгалд хамрагдах бүлгийн даатгуулагчийн шимтгэл,” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалтын “Нийгмийн даатгалын тухай хуулийн[3]” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн[3]” гэж, мөн зүйлийн 4.1.51 дэх заалтын “Нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтын “0-16” гэснийг “0-18” гэж, мөн зүйлийн 37.2.2 дахь заалтын “16” гэснийг “18” гэж, 37.2.2, 37.2.3 дахь заалтын “эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 37.3 дахь хэсгийн “комисс нийгмийн” гэснийг “зөвлөл нийгмийн” гэж, 37.4 дэх хэсгийн “37.2.1, 37.2.2-т” гэснийг “37.2.1-д” гэж, 37.5 дахь хэсгийн “37.2.1-37.2.3-т заасан комиссын” гэснийг “37.2.1, 37.2.2-т заасан комисс, зөвлөлийн” гэж, 37.9 дэх хэсгийн “комиссоос” гэснийг “зөвлөлөөс” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.15 дахь заалтын “тухай” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

Moehgo& Folo_ oa Heoll

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.4.а дэд заалт нэмсүгэй:

“73.1.4.а.ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хадгаламж, харилцах дансны төлбөр.”

**2 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “татварын өрөө барагдуулаагүй татвар” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөө барагдуулаагүй татвар, шимтгэл” гэж, мөн заалтын “татварын” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“8.Сар, улиралд батлагдсан цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг бүрэн тодорхойлоогүй, түүнд оногдох шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр үнэн зөв суутган тооцоогүйгээс үүссэн хохирлыг санд нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтлөөгүй, тайланг буруу гаргасан хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг буруу тогтоосон, эсхүл тогтоогоогүй хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Хуурамч баримт бичиг бүрдүүлэн тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үндэслэлгүйгээр илүү тогтоолгон авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг үндэслэлгүйгээр устгасан, засварласан, хуурамч мэдээлэл оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бус үйлдэл гаргаснаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн гарчгийн, 10.19 дүгээр зүйлийн тайлбарын “Нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.2, 8.4 дэх заалтыг, 10.17 дугаар зүйлийн тайлбарыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠶᠢᠯᠡᠭᠴᠢ ᠤ.ᠬᠦᠷᠡᠯᠰᠦᠬ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд[20]” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд[20]” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын тухай хуулиар[3]” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар[3]” гэж, 58 дугаар зүйлийн 58.1.3 дахь заалтын, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалтын, 80 дугаар зүйлийн 80.1.3 дахь заалтын, 85 дугаар зүйлийн 85.1.1 дэх заалтын “эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн” гэж, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 88 дугаар зүйлийн 88.4 дэх хэсгийн “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын” гэснийг “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.6 дахь хэсгийн “нийгмийн даатгалын дэвтэр,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 15 дахь хэсгийн “татварын өргүй” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр | Улаанбаатар хот

## ТАТВАРЫН ЗАРИМ ХУУЛЬ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн нэрийн “ДААТГАЛЫН ТУХАЙ” гэснийг “ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “даатгалын тухай” гэснийг “даатгалын ерөнхий” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг” гэснийг “даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалт” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Донорын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “Нийгмийн даатгалын тухай хуулийн[6] 28.2-т” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн[6] 43.5-д” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “тухай” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр | Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай[3]” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль[3]” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ ᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ ᠤ ᠡᠳᠦᠷ

ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠡᠷᠬᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠡᠷᠬᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒.᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ[3]» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠬᠠᠤᠯᠢ[3]» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠰᠦᠭᠡᠢ᠃

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠰᠡᠨ ᠨᠠᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ.ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай[2] хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн[2]” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий” гэж, мөн зүйлийн 4.1.3 дахь заалтын “Нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн “эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heoll

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд[1] заасны дагуу шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

2.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“тэтгэвэр” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.13-т заасныг;

2.1.2.“тэтгэвэр бодох нэрийн дансны арга” гэж даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэсэн нийт орлого, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэлд үндэслэн сард олгох тэтгэврийн хэмжээг тооцохыг;

2.1.3.“тэтгэвэр бодох цалинд үндэслэсэн арга” гэж даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээнд үндэслэн сард олгох тэтгэврийн хэмжээг тооцохыг;

2.1.4.“тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл” гэж даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш тэтгэвэр авах дундаж хугацааг;

2.1.5.“хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн[2] 6.1.41-д заасныг;

2.1.6.“цэргийн алба хаасан хугацаа” гэж Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн[3] 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг.

[1] Нийгмийн даатгалын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

[2] Татварын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

[3] Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

**3 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл**

3.1.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр дараах төрөлтэй байна:

3.1.1.өндөр насны;
3.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны;
3.1.3.тэжээгчээ алдсаны.

**4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэвэр**

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР

**5 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр авах эрх**

5.1.Доор дурдсан даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

5.1.1.тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн 65 насанд хүрсэн даатгуулагч;

5.1.2.тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй;

5.1.3.төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

5.1.4.нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 45 насанд хүрсэн эмэгтэй;

5.1.5.нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

5.1.6.нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

5.1.7.сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-иос доошгүй жил ажилласан, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил дурдсан мэргэжлээр ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, мөн төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч.

5.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 10-аас 20 хүртэл жил төлсөн энэ хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн даатгуулагч өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

5.3.Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, хэрэглэх журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: Энэ хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1957 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 60, 1962 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 55 байна. Цаашид 1958 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 60 нас 3 сар, 1963 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1977 он ба түүнээс хойш төрсөн эрэгтэй, 2002 он ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 65 байна.

-Энэ хуулийн 5.1.2-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 2023 онд 21 жил 6 сар байх бөгөөд энэ хугацааг 25 жил хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.

**6 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр бодох арга**

6.1.Өндөр насны тэтгэвэр бодох арга дараах төрөлтэй байна:

6.1.1.цалинд үндэслэсэн;
6.1.2.нэрийн дансны.

6.2.Өндөр насны тэтгэврийг бодоход даатгуулагч 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн бол энэ хуулийн 6.1.1-д заасан, 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн бол энэ хуулийн 6.1.2-т заасан аргыг хэрэглэнэ.

6.3.1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн, мөн энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч энэ хуулийн 6.1-д заасан аргаас өөрөө сонгоно.

**7 дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийн хэмжээг цалинд үндэслэсэн аргаар бодох**

7.1.Даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийн хэмжээг бодоход дараах томьёог хэрэглэнэ:

7.1.1.Өндөр насны бүрэн тэтгэврийн сарын хэмжээ:

$$Т_{цб} = Ц*(45\%+(Ш_{241+}*0.125\%))$$

$Т_{цб}$-цалинд үндэслэсэн аргаар тооцсон бүрэн тэтгэврийн сарын хэмжээ;
Ц-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
$Ш_{241+}$-241 ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо.

7.1.2.Өндөр насны хувь тэнцүүлэн тогтоох тэтгэврийн сарын хэмжээ:

$$Т_{цх} = Ц*0.1875\%*Ш_{сар}$$

$Т_{цх}$-цалинд үндэслэсэн аргаар тооцсон хувь тэнцүүлэн тогтоох тэтгэврийн сарын хэмжээ;
Ц-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
$Ш_{сар}$-шимтгэл төлсөн сарын тоо.

7.2.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлсөн бол тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн олгоно.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан нэмэгдлийг тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцож бодно.

7.4.2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийн хэмжээг бодоход энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлсөн сар тутамд 0.167 хувиар тооцно.

7.5.2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ хуулийн 7.2-т заасан нэмэгдлийг тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлсөн сар тутамд 0.167 хувиар тооцно.

7.6.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

**8 дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийн хэмжээг нэрийн дансны аргаар бодох**

8.1.Даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийн хэмжээг бодоход дараах томьёог хэрэглэнэ:

$$Т_{НД}=НД_{СЗ}/12К$$

$Т_{НД}$-нэрийн дансны аргаар тооцсон сарын тэтгэврийн хэмжээ;
$НД_{СЗ}$-Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27.8-д заасны дагуу тооцсон нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүн;
К-тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл.

8.2.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлсөн бол уг хугацаанд бүртгэгдсэн нэрийн дансны орлогыг тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллээс тэтгэвэр авсан хугацааг хассан илэрхийлэлд хувааж тооцсон дүнгээр сарын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

8.3.Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно.

**9 дүгээр зүйл.Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт**

9.1.Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ:

9.1.1.Гэр бүлийн тухай хуулийн[4] 7.1-д зааснаар бүртгүүлсэн;

9.1.2.20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ нь нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцүү байна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан тэтгэврийн нэмэгдлийг тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн олгоно.

9.4.Энэ хуулийн 9.1-д заасан нас барсан тэтгэвэр авагч нь 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгон авч байсан бол түүний нөхөр, эсхүл эхнэрт олгох тэтгэврийн нэмэгдлийн зардлыг улсын төсвөөс хариуцна.

**10 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа**

10.1.Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг нийгмийн даатгалын байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

**11 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх**

11.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил, эсхүл хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

11.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

[4] Гэр бүлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

11.3.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан даатгуулагч хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээгдсэнээс хойш 6 сарын дотор дахин хөдөлмөрийн чадвараа алдсан бол өмнө нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход баримталсан цалин хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацаагаар тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**12 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох**

12.1.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтооно.

**13 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээ**

13.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийн хэмжээг энэ хуулийн 7.1.1, 7.4-т заасны дагуу тооцсон тэтгэврийн хэмжээнээс хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан бол 100 хувиар, 50-69 хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тус тус бодож тооцно.

13.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн хэмжээг энэ хуулийн 7.1.2, 7.4-т заасны дагуу тооцсон тэтгэврийн хэмжээнээс хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан бол 100 хувиар, 50-69 хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тус тус бодож тооцно.

**14 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох хугацаа**

14.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барсан бол нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.

**15 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн тогтоож, тэтгэврийг нөхөн олгох**

15.1.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хугацаа нь дууссанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаанаар тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаагаа нөхөн сунгуулсан бол түүний 2 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

### 16 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх

16.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил, эсхүл нас барахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч, эсхүл өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн доор дурдсан гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

16.1.1.төрсөн, дагавар, үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд /үүнд эцгээ нас барснаас хойш төрсөн хүүхэд хамаарна/;

16.1.2.тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;

16.1.3.тэжээгчийн хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ач, зээ;

16.1.4.тэжээгчийг нас барахын өмнө энэ хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон эхнэр, нөхөр, тэжээн тэтгэх өөр хүнгүй эцэг, эх.

16.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс 12 сар нь тасралтгүй төлсөн даатгуулагч нас барсан бол түүний энэ хуулийн 16.1-д заасан гэр бүлийн гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

### 17 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ

17.1.Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн хэмжээг нас барсан даатгуулагчийн авч байсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос энэ хуулийн 7.1.1, 7.4-т заасны дагуу тооцсон тэтгэврийн хэмжээнээс нас барсан даатгуулагчийн асрамжид байсан энэ хуулийн 16.1-д заасан гэр бүлийн гишүүний тооноос хамааруулан дараах хувь хэмжээгээр бодож тооцно:

| Гэр бүлийн гишүүний тоо | Тэтгэвэр бодох хувь хэмжээ |
|---|---|
| 3 ба түүнээс дээш | 100 |
| 2 | 75 |
| 1 | 50 |

17.2.Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн хэмжээг нас барсан даатгуулагчийн авч байсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос энэ хуулийн 7.1.2, 7.4-т заасны дагуу тооцсон тэтгэврийн хэмжээнээс энэ хуулийн 17.1-д заасан хувь хэмжээгээр бодож тооцно.

17.3.Энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан гэр бүлийн гишүүний хоёр тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг тэдгээрийн авч байсан сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрээс тооцсон сарын дундаж цалин хөлснөөс энэ хуулийн 17.1, 17.2-т заасны дагуу бодож тооцно.

17.4.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

**18 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох хугацаа, нөхөн олгох**

18.1.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хүүхдэд 19 нас хүртэл, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, энэ хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сарыг дуустал тус тус олгоно.

18.2.Тэжээгчийг сураггүй алга болсныг нь тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд 60 хүртэлх сарын тэтгэврийг энэ хуулийн 16.1-д заасан гэр бүлийн гишүүнд нөхөн олгоно.

**19 дүгээр зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нэгтгэн тогтоох**

19.1.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан энэ хуулийн 16.1-д заасан гэр бүлийн бүх гишүүнд нэгтгэн нэг тэтгэвэр тогтооно.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу тогтоосон тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан гишүүний хүсэлтээр гишүүн бүрд тэнцүү хэмжээгээр хуваан олгож болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТЭТГЭВЭР ТОГТООХ, ОЛГОХ

**20 дугаар зүйл.Тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох**

20.1.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60-д хувааж бодно.

20.2.Даатгуулагч 5 жилээс доош хугацаанд шимтгэл төлсөн байх нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг түүний шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваах бодно.

20.3.Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохдоо даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ.

20.4.Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохоор сонгосон дараалсан жилийн сар бүрийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь тухайн үед мөрдөж байсан нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

20.5.Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох 1995 оноос өмнөх хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын, эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд тэтгэврийн хэмжээг үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан бодно.

20.6.Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.7.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**21 дүгээр зүйл.Тэтгэврийн доод хэмжээ**

21.1.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг доор дурдсанаар Засгийн газар тогтооно:

21.1.1.энэ хуулийн 5.1, 11.1, 16.1-д заасны дагуу тэтгэвэр тогтоолгон авах эрх үүссэн даатгуулагч, иргэний тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байхаар;

21.1.2.энэ хуулийн 5.2, 11.2, 16.2-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгон авах эрх үүссэн даатгуулагч, иргэний тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байхаар.

21.2.Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээг нэг хүнд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар, хоёр хүнд 75 хувиар, гурав ба түүнээс дээш хүнд 100 хувиар тус тус тогтооно.

**22 дугаар зүйл.Тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа**

22.1.Даатгуулагч тэтгэвэр тогтоолгох шаардлагатай баримт бичиг, өргөдлийг доор дурдсан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

22.1.1.өндөр насны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгон авахыг хүссэн хугацаанд;

22.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосноос хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол гурван сарын дотор;

22.1.3.тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барснаас хойш 30 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор.

22.2.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагч, эсхүл даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэвэр тогтоох асуудлыг түүний тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

22.3.Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

22.4.Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**23 дугаар зүйл.Тэтгэвэр олгох**

23.1.Нийгмийн даатгалын байгууллага энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан тэтгэврийг тэтгэвэр авагчийн сонгосон арилжааны банкаар дамжуулан сар бүр олгоно.

23.2.Өндөр насалсан болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэврээ өөрийн биеэр авах боломжгүй тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид, тэтгэвэр авагч иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, чадамж хязгаарлагдсан бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгож болно.

23.3.14 ба түүнээс доош насны хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д олгоно.

23.4.Тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн сарын тэтгэврийг тэтгэвэр авагчийн гэр бүлийн гишүүнд нийгмийн даатгалын байгууллагаас олгосон мэдэгдэлд үндэслэн арилжааны банкаар дамжуулан олгоно.

23.5.Даатгуулагч энэ хуулийн 22.1-д заасан хугацаанаас хойш тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн бол тэтгэврийг тогтоож, нийгмийн даатгалын байгууллага өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн тооцож, олгоно.

23.6.Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өөрчлөх өргөдөл, холбогдох баримт бичгийг тухайн сарын 15-ны өдрөөс өмнө хүлээж авсан бол мөн сарын 01-ний өдрөөс, тухайн сарын 15-ны өдрөөс хойш хүлээж авсан бол дараа сарын 01-ний өдрөөс эхлэн өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.

**24 дүгээр зүйл.Тэтгэвэр олголтыг түдгэлзүүлэх, зогсоох, сэргээх**

24.1.Тэтгэвэр олголтыг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

24.1.1.хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хугацаа нь дууссанаас хойш тэтгэвэр авагч 14 хоногийн дотор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулаагүй;

24.1.2.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, эрх бүхий байгууллагын хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн.

24.2.Тэтгэвэр олголтыг дараах үндэслэлээр доор дурдсан хугацаанаас эхлэн зогсооно:

24.2.1.хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр авсан бол нийгмийн даатгалын улсын байцаагчийн актад заасан хугацаанаас;

24.2.2.тэтгэвэр авагчийг нас барсны дараагийн сарыг дууссан өдрөөс, эсхүл тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс;

24.2.3.тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсны дараагийн сарын 01-ний өдрөөс;

24.2.4.Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Монгол Улсад байнга оршин суугаа тэтгэвэр авагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн[5] 33.3-т заасны дагуу оршин суух үнэмлэхээ хураалгасны дараагийн сарын 01-ний өдрөөс;

[5] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

24.2.5.тэтгэвэр авагч өөр төрлийн тэтгэврийг сонгосон тохиолдолд шинээр тогтоолгосон тэтгэврийг олгож эхэлсэн өдрөөс;

24.2.6.тэтгэврийг түдгэлзүүлснээс хойш 6 сарын дотор тэтгэврээ сэргээлгээгүй бол дараагийн сарын 01-ний өдрөөс.

24.3.Түдгэлзүүлсэн, зогсоосон тэтгэврийг дараах тохиолдолд сэргээнэ:

24.3.1.энэ хуулийн 24.1.1-д заасны дагуу түдгэлзүүлсэн тэтгэврийг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр гарсан өдрөөс;

24.3.2.энэ хуулийн 24.1.2-т заасны дагуу түдгэлзүүлсэн тэтгэврийг эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан өдрөөс;

24.3.3.тэтгэвэр тогтоолгосон нөхцөл зөв болох нь нотлогдсон бол холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдөл хүлээн авсан өдрөөс;

24.3.4.тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг нь тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр гарсан өдрөөс.

24.4.Энэ хуулийн 24.3.4-т заасан шүүхийн шийдвэрийг үндэслэн тэтгэвэр олголтыг сэргээсэн тохиолдолд 60-аас ихгүй сарын тэтгэврийг нөхөн олгоно.

**25 дугаар зүйл.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох, олгох**

25.1.Тэтгэврийн хэмжээг дараах тохиолдолд өөрчлөн тогтооно:

25.1.1.тэтгэврийг нь тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа болон цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэлийн хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй бол;

25.1.2.тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлсөн бол;

25.1.3.хөдөлмөрийн чадвар алдалтын хувьд өөрчлөлт орсон бол;

25.1.4.нас барсан тэжээгчийн асрамжид байсан гэр бүлийн гишүүний тоонд өөрчлөлт орсон бол;

25.1.5.тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байсан 19 нас хүрээгүй хүүхдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоогдох эрх дахин үүссэн бол.

25.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн бол тогтоосон өндөр насны тэтгэврийн хэмжээ нь өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс багагүй байна.

25.3.Тэтгэвэр авагч нь энэ хуулийн 25.1.3, 25.1.4-т заасан өөрчлөлтийг нийгмийн даатгалын байгууллагад тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

**26 дугаар зүйл.Тэтгэврээс суутгал хийх**

26.1.Тэтгэврээс дараах үндэслэлээр суутгал хийнэ:

26.1.1.хуурамч баримт бичиг бүрдүүлсний улмаас үндэслэлгүйгээр тэтгэвэр авсан нь нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоогдсон бол;

26.1.2.тэтгэвэр авагч энэ хуулийн 25.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс тэтгэвэр илүү авсан нь нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоогдсон бол.

26.2.Тэтгэврээс нэг удаа суутгах суутгалын хэмжээ нь тэтгэвэр авагчийн сарын тэтгэврийн хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.

26.3.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд тэтгэврээс суутгал хийхийг хориглоно.

**27 дугаар зүйл.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх**

27.1.Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

27.3.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт жил бүр тусгана.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль[6], Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль[7], эсхүл Эрүүгийн хуульд[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**29 дүгээр зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт**

29.1.Энэ хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

29.2.Энэ хуулийн 7.1, 7.3 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно.

29.4.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тогтоосон тэтгэврийг энэ хуулийн 25.1, 29.3-т зааснаас бусад тохиолдолд өөрчлөн тогтоохгүй.

**30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

[6] Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[7] Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.
[8] Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1994 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1999 оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталсан Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heol I

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр | Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

## Moehgol Folo_ oa Heol l

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ
ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠍. ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр | Улаанбаатар хот

## СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Статистикийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь заалтын “тахир дутуу болсон” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэж, “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр | Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

**1/17² дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Цэргийн алба хаагч эхэд тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.”

**2/18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.”

**3/19 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 2-т заасан тэтгэмжийн хэмжээ нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу тогтоосон хэмжээтэй тэнцүү байна. Уг тэтгэмжийг улсын төсвөөс олгоно.”

**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байхаар, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байхаар Засгийн газар тогтооно.”

**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн

тухай хуулийн 16 дугаар” гэж, 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д” гэж, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, 24 дүгээр зүйлийн “нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠰᠠᠢᠳ

ᠯ᠂ ᠣᠶᠤᠨ-ᠡᠷᠳᠡᠨᠢ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.2 дахь заалтын “тахир дутуу болсон” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэж, “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, мөн зүйлийн 39.5 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль[3]” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль[3]” гэж, 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх заалтын “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтын “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ ᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ ᠦ ᠡᠳᠦᠷ

## ᠭᠦᠢᠴᠡᠳᠭᠡᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠭᠦᠢᠴᠡᠳᠭᠡᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠢᠨ ᠑᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠖.᠕ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠩ ᠠᠴᠠ ᠣᠯᠭᠣᠬᠤ ᠲᠡᠳᠬᠦᠭᠡᠪᠦᠷᠢ᠂ ᠲᠡᠳᠬᠦᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠩ ᠠᠴᠠ ᠣᠯᠭᠣᠬᠤ ᠲᠡᠳᠬᠦᠭᠡᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠢ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠳᠬᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠩ ᠠᠴᠠ ᠣᠯᠭᠣᠬᠤ ᠲᠡᠳᠬᠦᠭᠡᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠊ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “тахир дутуу болсон” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэж, “тахир дутуугийн тэтгэвэр,” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр,” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “тахир дутуу болсон” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэж, “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.2 дахь хэсэг нэмсүгэй:

“12.2.Энэ хуулийн 12.1.1-д заасан иргэнд тэтгэвэр олгоход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насыг баримтална.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт:**

“12.1.1.65 насанд хүрсэн иргэн;”

**2/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:**

“27.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга батална.”

**3/27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг:**

“27.6.Зөвлөлийн үйл ажиллагаанд сум, хорооны Засаг дарга, аймаг дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга хяналт тавьж ажиллана.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgol Folo_oa Heol

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:**

“8.2.Энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалах ахмад настанд олгох нэмэгдлийг сар бүр, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөнгөлөлтийг тухай бүр ахмад настны арилжааны банкан дахь нэрийн дансанд шилжүүлнэ.”

**2/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:**

“8.5.Ахмад настны хүсэлтээр нэмэгдэл, хөнгөлөлтийг түүний хадгаламжийн дансанд шилжүүлж болно.”

**2 дугаар зүйл.**Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Нийгмийн халамжийн үйлчилгээний” гэснийг “Энэ хуулийн 8.2-т заасан байгууллага болон холбогдох” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heol

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалд шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэмж олгох, ажлын байрыг тогтвортой хадгалсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, хөнгөлөлт, шимтгэлийн төлбөр**

2.1.Тэтгэмжийн даатгалын сангаас дараах тэтгэмж, шимтгэлийн төлбөрийг олгоно:

2.1.1.хөдөлмөрийн чадвар түр алдсаны;
2.1.2.жирэмсний болон амаржсаны;
2.1.3.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох;
2.1.4.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.

2.2.Ажилгүйдлийн даатгалын сангаас дараах тэтгэмж, хөнгөлөлтийг олгоно:

2.2.1.ажилгүйдлийн тэтгэмж;
2.2.2.шимтгэлийн хөнгөлөлт.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

**3 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх**

3.1.Хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх дараалсан гурав ба түүнээс дээш сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн дараах даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй:

3.1.1.ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагч;

3.1.2.хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу Эрүүл мэндийн тухай хуулийн[1] 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагч эх.

3.2.Даатгуулагч энэ хуулийн 5.2, 5.3, 5.4-т заасан хугацаанд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч дууссаны дараа тэтгэмжийн даатгалын санд дараалсан гурван сараас доошгүй хугацаагаар шимтгэл төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх дахин үүснэ.

### 4 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ

4.1.Даатгуулагчид олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан гурван сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дараах хувь хэмжээгээр тооцно:

| | Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа /сараар/ | Тэтгэмж бодох хэмжээ /хувиар/ |
|---|---|---|
| 1. | 3-59 | 50 |
| 2. | 60-119 | 55 |
| 3. | 120-179 | 60 |
| 4. | 180 ба түүнээс дээш | 75 |

4.2.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

### 5 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа

5.1.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний таван өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, зургаа дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно.

5.2.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь ажлын 66 өдрөөс хэтрэхгүй байна.

5.3.Даатгуулагч хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийтдээ ажлын 132 өдрөөс илүүгүй хугацаанд олгоно.

[1] Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

5.4.Хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь ажлын 132 өдрөөс хэтрэхгүй байна.

5.5.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааг ерөнхий эмч, их эмч, эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комисс тогтоож, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгоно.

5.6.Эмнэлгийн хуудасны маягтын загвар, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

5.7.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид тэтгэвэр тогтоолгосон тухайн өвчний оношоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохгүй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

### 6 дугаар зүйл.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх

6.1.Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 12 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс жирэмсний амралт авахын өмнөх сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн дараах даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй:

6.1.1.хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж төрүүлсэн эх;

6.1.2.хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эх;

6.1.3.хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж дутуу төрүүлсэн буюу Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагч эх.

### 7 дугаар зүйл.Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа

7.1.Даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг жирэмсний амралт авсан сарын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 120 хоногийн, ихэр хүүхэд төрүүлсэн бол 140 хоногийн хугацаанд тус тус олгоно.

7.2.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

### 8 дугаар зүйл.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох нөхцөл, хэмжээ

8.1.Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаанд төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

8.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд[2] заасан тэтгэвэр авч байсан иргэн нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

8.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ, ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ

### 9 дүгээр зүйл.Ажилгүйдлийн тэтгэмж авах, шимтгэлийн хөнгөлөлт эдлэх эрх

9.1.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

9.2.Ажилгүйдлийн тэтгэмж урьд нь авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж авах эрх дахин үүснэ.

9.3.Хүүхдээ асрах чөлөө авахаас өмнө энэ хуулийн 9.1-д заасан эрхийг хангасан даатгуулагч эхийг хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд, эсхүл ажилд ороод 9 сар хүртэлх хугацаанд ажил олгогч нь татан буугдсан, дампуурсан бол түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

[2] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

9.4.Цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар татагдсан, хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, байгууллагын захиалгаар суралцах, хөдөлмөрийн чадвар алдсаны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

**10 дугаар зүйл.Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ**

10.1.Даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дараах хувь хэмжээгээр тооцож олгоно:

| | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа /сараар/ | Тэтгэмж бодох хэмжээ /хувиар/ |
|---|---|---|
| 1. | 24-59 | 50 |
| 2. | 60-119 | 55 |
| 3. | 120-179 | 60 |
| 4. | 180 ба түүнээс дээш | 70 |

10.2.Энэ хуулийн 9.3-т заасан даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлж ажилласан сүүлийн 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас энэ хуулийн 10.1-д заасан хувь хэмжээгээр тооцно.

**11 дүгээр зүйл.Ажилгүйдлийн тэтгэмж олгох**

11.1.Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно.

11.2.Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.

11.3.Даатгуулагч энэ хуулийн 14.1.3-т заасан хугацаанаас хойш ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон холбогдох баримт бичгийн хамт нийгмийн даатгалын байгууллагад бүрдүүлж өгсөн бол уг хугацаанаас хоцроосон ажлын өдрийг энэ хуулийн 11.1-д заасан өдрөөс хасаж тооцон ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

11.4.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлснээс хойш 5 сарын дотор ажлаас дахин чөлөөлөгдсөн бол анх тогтоосон ажилгүйдлийн тэтгэмжээс олгогдоогүй үлдсэн тэтгэмжийг олгоно.

11.5.Нийгмийн даатгалын байгууллага ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн арилжааны банкан дахь дансаар дамжуулан сар бүр олгоно.

**12 дугаар зүйл.Ажилгүйдлийн тэтгэмж олголтыг зогсоох**

12.1.Ажилгүйдлийн тэтгэмж олголтыг дараах үндэслэлээр зогсооно:

12.1.1.ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлсэн;

12.1.2.өндөр насны, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон;

12.1.3.үндэслэлгүйгээр ажилгүйдлийн тэтгэмж авч байсан нь тогтоогдсон;

12.1.4.цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар татагдсан;

12.1.5.хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

12.1.6.ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд нас барсан.

**13 дугаар зүйл.Шимтгэлийн хөнгөлөлт**

13.1.Даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулан 3 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар[3] хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан шимтгэлийн хөнгөлөлтийг дараа жилийн төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэлээс хасаж тооцно.

13.3.Ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

[3] Нийгмийн даатгалын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

**14 дүгээр зүйл.Тэтгэмж авах өргөдөл гаргах хугацаа**

14.1.Даатгуулагч, иргэн тэтгэмж авах өргөдлөө нийгмийн даатгалын байгууллагад дараах хугацаанд цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

14.1.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

14.1.2.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

14.1.3.ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагч ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр гарсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор.

**15 дугаар зүйл.Өргөдлийг шийдвэрлэх хугацаа**

15.1.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн тэтгэмж авахыг хүссэн өргөдлийг энэ хуулийн 15.2-т заасан журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт хүлээж авснаас хойш хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж олгох асуудлыг 14 хоногийн дотор, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

15.2.Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

15.3.Энэ хуулийн 15.1-д заасан өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**16 дугаар зүйл.Тэтгэмжийг буцаан төлүүлэх, суутгал хийх**

16.1.Даатгуулагчийн үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэмжийг төлүүлэхээр нийгмийн даатгалын улсын байцаагчийн, эсхүл нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийн актаар тогтоогдсон бол илүү авсан тэтгэмжийг даатгуулагчаар буцаан төлүүлэх буюу олгогдоогүй үлдсэн тэтгэмжээс суутган авна.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**17 дугаар зүйл.Тусгай зохицуулалт**

17.1.Улс орныг хамарсан эдийн засгийн хүндрэлийн улмаас нийт аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа доголдож, олонх аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлого 50 ба түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, даатгуулагчид тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулж болно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан тусгай хуулиар зохицуулах санхүүгийн дэмжлэг, тэтгэмжид зарцуулах хөрөнгийг ажилгүйдлийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцна.

**18 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль[4], Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[5], эсхүл Зөрчлийн тухай хуульд[6] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

---
[4] Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[5] Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[6] Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр — Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1994 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай[4]” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай[4]” гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “ажилгүйдлийн тэтгэмжийн” гэснийг “тэтгэмжийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТЭТГЭМЖИЙН ДООД ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1991 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

2.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“мэргэжлээс шалтгаалсан өвчин” гэж хөдөлмөрлөх явцад хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэсэн архаг болон хурц эмгэгийг;

2.1.2.“ортопед” гэж нуруу, мөчдийн бүтцийн өөрчлөлт болон үйл ажиллагааны алдагдлын үед хөдөлгөөнийг дэмжих, хязгаарлах, хянах, ясыг шугаман дагуу байрлуулж, засахад зориулагдсан хэрэгслийг;

2.1.3.“протез” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн[1] 3.1.16-д заасныг;

2.1.4.“үйлдвэрлэлийн осол” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн[2] 3.1.20-д заасныг;

2.1.5.“хурц хордлого” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.10-т заасныг.

---

[1] Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

[2] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

**3 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин**

3.1.Даатгуулагч дараах нөхцөл байдлын үед үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

3.1.1.ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байх үед;

3.1.2.ажил олгогч, эрх бүхий этгээд болон албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар ажиллаж, ажил үүрэг гүйцэтгэж байх үед;

3.1.3.ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед;

3.1.4.ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байранд амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

3.1.5.ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн[3] 93.1.1-д заасан амрах, хооллох завсарлагын үед;

3.1.6.хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах аюулт үзэгдлийн үед;

3.1.7.үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж эвдрэх, нурах, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох ослын үед;

3.1.8.олон улсын болон улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох явцад.

3.2.Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэх явцад гэмт хэрэг үйлдсэн, эсхүл санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй.

3.3.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, тогтоохтой холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулна.

3.4.Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

[3] Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ШИМТГЭЛИЙН ТӨЛБӨР

**4 дүгээр зүйл.Даатгуулагчид олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт**

4.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ:

4.1.1.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр;
4.1.2.тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
4.1.3.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
4.1.4.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж;
4.1.5.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөр;

4.1.6.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр;

4.1.7.даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр;

4.1.8.ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт.

**5 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх, тэтгэврийн хэмжээ**

5.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

5.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар тогтооно.

5.3.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн[4] 37.7-д заасан зөвлөл тогтооно.

5.4.Даатгуулагчийн тэтгэвэр бодох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

[4] Нийгмийн даатгалын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

5.4.1.даатгуулагч 12 сар ба түүнээс дээш хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол түүний хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 12-т хуваасан хэмжээгээр;

5.4.2.даатгуулагч 12 сараас доош хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол түүний хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх шимтгэл төлсөн нийт цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд хуваасан хэмжээгээр;

5.4.3.даатгуулагч 1 сараас доош хугацаанд ажиллаж байх үед хөдөлмөрийн чадвараа алдсан бол ажилд томилсон шийдвэрээр тогтоосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээгээр.

5.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар, 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0.167 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

**6 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох хугацаа, тэтгэврийг нөхөн олгох**

6.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барсан бол нас барсны дараагийн сар дуустал олгоно.

6.2.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар тогтоолгож чадаагүй байсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаныг нөхөн тогтоосон бол 6 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгож болно.

6.3.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хугацаа дууссанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаанаар тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацааг нөхөн сунгуулсан бол түүний 2 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгоно.

**7 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх, хэмжээ, олгох хугацаа, тэтгэврийг нөхөн олгох нөхцөл**

7.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх бүхий гишүүнийг тогтооход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн[5] 16.1-д заасныг баримтална.

7.3.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дараах хувь хэмжээгээр тогтооно:

| | Хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоо | Тэтгэвэр бодох хувь хэмжээ |
|---|---|---|
| 1. | 3 ба түүнээс дээш | 100 |
| 2. | 2 | 75 |
| 3. | 1 | 50 |

7.4.Даатгуулагчийн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг энэ хуулийн 5.4-т заасны дагуу тодорхойлно.

7.5.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнд нэгтгэн нэг тэтгэвэр тогтооно.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасны дагуу тогтоосон тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний хүсэлтээр гишүүн бүрд тэнцүү хэмжээгээр хуваан олгож болно.

7.7.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хүүхдэд 19 нас хүртэл, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустал олгоно.

7.8.Даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсныг нөхөн тогтоосон бол 6 сараас илүүгүй хугацааны тэжээгчээ алдсаны тэтгэврийг нөхөн олгож болно.

**8 дугаар зүйл.Тэтгэврийн доод хэмжээ**

8.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21.1.1, 21.2-т заасан хэмжээтэй тус тус адил байна.

[5] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

**9 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа**

9.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

9.2.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан түүний сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 100 хувиар тооцно.

9.3.Даатгуулагчийн тэтгэмж бодох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг доор дурдсанаар тодорхойлно:

9.3.1.даатгуулагч 3 сар ба түүнээс дээш хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан бол түүний хөдөлмөрийн чадвар түр алдахын өмнөх 3 сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 3-т хуваасан хэмжээгээр;

9.3.2.даатгуулагч 3 сараас доош хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан бол түүний хөдөлмөрийн чадвар түр алдахын өмнөх шимтгэл төлсөн нийт цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд хуваасан хэмжээгээр;

9.3.3.даатгуулагч 1 сараас доош хугацаанд ажиллаж байх үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол ажилд томилсон шийдвэрээр тогтоосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээгээр.

9.4.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

9.5.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацаанд олгоно.

9.6.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны дээд хязгаар нь дараалсан 12 сарын дотор 180 хоногоос хэтрэхгүй байна.

9.7.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааг ерөнхий эмч, их эмч, эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комисс тогтоож, эмнэлгийн хуудас олгоно.

9.8.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид тухайн тэтгэвэр тогтоолгосон өвчний оношоор хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг давхардуулан олгохгүй.

**10 дугаар зүйл.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ**

10.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

10.2.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэтгэвэр авагч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

10.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн[6] 8.3-т заасны дагуу тогтоосон хэмжээтэй адил байна.

**11 дүгээр зүйл.Тэтгэвэр, тэтгэмж авах өргөдөл гаргах, түүнийг шийдвэрлэх хугацаа**

11.1.Даатгуулагч, иргэн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг бүрдүүлсэн баримт бичгийн хамт дараах хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

11.1.1.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоолгосноос хойш 14 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор;

11.1.2.тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ нас барснаас хойш 30 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

11.1.3.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослын акт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолт авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

[6] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

11.1.4.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор.

11.2.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох асуудлыг түүний тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 14 хоногийн дотор, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

11.3.Даатгуулагч энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

**12 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөр**

12.1.Хөдөлмөр эрхлээгүй, энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөрийг түүний хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлнө.

12.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөрийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1-д заасан даатгуулагчийн төлбөл зохих хувь хэмжээгээр тооцож үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд төлнө.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

**13 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

13.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг хамааруулна:

13.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгаа;

13.1.2.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;

13.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах;

13.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээ.

13.2.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.

13.3.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 14 дүгээр зүйл.Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр

14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно:

14.1.1.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон протез, ортопедийн;

14.1.2.сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний;

14.1.3.сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны.

14.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

14.3.Протез, ортопедийн зардлын төлбөрийг энэ хуулийн 14.2-т заасны дагуу баталсан жишиг үнийг баримтлан 3 жил тутамд нэг удаа олгоно.

14.4.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу зайлшгүй шаардлагаар протез, ортопедийг гадаад улсад хийлгэсэн бол түүний зардлын төлбөрийг энэ хуулийн 14.2-т заасны дагуу баталсан протез, ортопедийн жишиг үнийг баримтлан 3 жил тутамд нэг удаа олгож болно.

14.5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас, эсхүл нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй.

14.6.Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сэргээн засах төв, сувилалд эмчлүүлсэн болон ирэх, буцах унааны зардлын төлбөрийг жилд нэг удаа олгоно.

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.8.Сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тухайн үед мөрдөж байгаа үнийг үндэслэн тооцно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

14.10.Даатгуулагч энэ зүйлд заасан зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

**15 дугаар зүйл.Ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт**

15.1.Ажил олгогчид дараах тохиолдолд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ:

15.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулсан тохиолдолд шимтгэлийн хөнгөлөлт;

15.1.2.үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон болон энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн чөлөөлөлт.

15.2.Энэ хуулийн 15.1.1-д заасан шимтгэлийн хөнгөлөлтийг дараах нөхцөлийг 3 жил дараалан хангасан ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 15 хүртэлх хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа үзүүлнэ:

15.2.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй;

15.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн;

15.2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5-д заасны дагуу хийлгэсэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ажлын байран дахь эрсдэлийг арилгасан.

15.3.Ажил олгогчид үзүүлэх энэ хуулийн 15.1.1-д заасан шимтгэлийн хөнгөлөлтийг дараа жилийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс хасаж тооцно.

15.4.Энэ хуулийн 15.1.2-т заасан сул зогсолтын хугацааг ажил олгогчийн санал, холбогдох мэдээлэл, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

15.5.Энэ хуулийн 15.1.2-т заасан тохирсон ажлын байраар хангагдсан ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцон ажил олгогчоос хариуцан төлөх шимтгэлийг 12 хүртэлх сарын хугацаанд чөлөөлнө.

15.6.Ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт хэмжээ нь ажил олгогчийн тухайн жилд төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

15.7.Ажил олгогчид хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН

### 16 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдүүлэлт

16.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/ нь ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, мэдээлэл, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн болон эрсдэлийн үнэлгээ, ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон холбогдох бусад мэдээллийг агуулсан байна.

16.2.Мэдээллийн сан нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, тооцоолол хийх, шимтгэлийн хувь хэмжээ тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

16.3.Мэдээллийн санг дараах байгууллага бүрдүүлнэ:

16.3.1.ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, холбогдох бусад мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

16.3.2.үйлдвэрлэлийн ослын тоо, шалтгаан, нөхцөл, холбогдох бусад мэдээллийг хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

16.3.3.ажил олгогчийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн үнэлгээний мэдээллийг уг үнэлгээг хийж байгаа эрх бүхий байгууллага болон ажил олгогч.

16.4.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**17 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах**

17.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна.

**18 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль[7], Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[8], эсхүл Зөрчлийн тухай хуульд[9] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

[7] Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[8] Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[9] Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1994 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2023 он №31/1279/

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “Эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.6 дахь хэсэг нэмсүгэй:

“9.6.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 16.3.2-т заасан мэдээллийг бүрдүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН<br>ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот |

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэж нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 9.25
**Индекс: 200003**